



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 604

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар дахин худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Архангай аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 31,000,000.00 (гучин нэгэн сая) төгрөгийн балансын үнэ, 24,465,653.00 (хорин дөрвөн сая дөрвөн зуун жаран таван мянга зургаан зуун тавин гурван) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдсугай.

2.Нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу 3,270,000.00 (гурван сая хоёр зуун далан мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

3.Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Занданбат, Архангай аймгийн Татварын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч Г.Чулуунбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, захиргааны актын дагуу зохион байгуулах;

3.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.3.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;


3.4.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ГАВАА

0002622

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн
өдрийн 604 дугаар тогтоолын хавсралт

Архангай аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдах автомашин

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2018 оны 390 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)
1	Ландкрузер-80, 76-77 АРА, арал №ННDJ810065130	1996/ 2010	31,000,000.00	24,465,653.00	6,534,347.00	6,540,000.00	3,270,000.00	817,500.00
	Нийт дүн		31,000,000.00 (гучин нэгэн сая)	24,465,653.00 (хорин дөрвөн сая дөрвөн зуун жаран таван мянга зургаан зуун тавин гурван)	6,534,347.00 (зургаан сая таван зуун гучин дөрвөн мянга гурван зуун дөчин долоон)	6,540,000.00 (зургаан сая таван зуун дөчин мянга)	3,270,000.00 (гурван сая хоёр зуун далан мянган)	817,500.00 (найман зуун арван долоон мянга таван зуун)